



Зөхиргөөны хэмжээгээр
агтын улсын нэгдсэн оронд
2019 оны 04 сарын 03-ны
үдрийн 435/ дугаар бүртгэл.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 3 сарын 20 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

“Зээлийн батлан даалтын сангийн үйл
ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ыг
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 14 дүгээр зүйлийн 14.2 дах хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 238 дугаар тогтоолоор баталсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /М.Өлзийбат/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос Зээлийн батлан даалтын сан /цаашид “Сан” гэх/-гийн үйл ажиллагааны шаардлага, зохистой харьцааг тогтоож, өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журам нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

ХОЁР. САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2.1.Сангийн үйл ажиллагаанд дараах шаардлагыг тавина:

2.1.1.Сан нь олон улсын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээний нөхцөл, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх талаар урьдчилан Хороонд мэдэгдэж, мэдээлэл ирүүлж байх;

2.1.2.батлан даалтын мэдээ тайлан гаргахдаа банк, санхүүгийн байгууллагад мөрдөж байгаа активыг ангилахтай холбоотой журмыг мөрдөж ажиллах;

2.1.3.Сангийн өөрийн хөрөнгө болон сангийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй хөрөнгийн эх үүсвэрийг байршуулахдаа тухайн банк, санхүүгийн байгууллагын эрсдэлийг тооцож шийдвэр гаргах;

2.1.4.хөрөнгийн эх үүсвэрийг банк, санхүүгийн байгууллагад байршуулах дараа оны төлөвлөгөөг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлж байх;

2.1.5.тухайн батлан даалтын хүсэлтийг зээлийн батлан даалтын хороо хэлэлцэж 2 удаа татгалзсан шийдвэр гаргасан тохиолдолд уг хүсэлтийг 1 жилийн дотор дахин хянаж, хэлэлцэхгүй байх; [СЗХ-ны 2020.06.10-ны 352, 2021 оны 65-р, 2021 оны 385-р тогтоолоор орсон өөрчлөлтийг тусгав.](#)

2.1.6.зээлдэгч болон түүний холбогдох этгээд нь гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангаагүй тохиолдолд дахин батлан даалт гаргахгүй байх.

2.2.Сан нь дараах шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна:

2.2.1.Сангийн өөрийн хөрөнгө нь 5,000,000,000 / таван тэрбум/ төгрөгөөс доошгүй мөнгөн хөрөнгөөр бүрдүүлсэн байх;

2.2.2.Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх хоршооны гишүүн малчинд гаргах зээлийн батлан даалтын хэмжээ нь банк, санхүүгийн байгууллагаас авах тухайн зээлийн 100 хүртэлх хувь, бусад төрлийн нэг зээлдэгч болон түүний холбогдох этгээдэд гаргах зээлийн батлан даалтын хэмжээ нь банк, санхүүгийн байгууллагаас авах тухайн зээлийн 60 хүртэл хувь буюу сангийн өөрийн хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй. [Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 428 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан.](#)

[СЗХ-ны 2020.06.10-ны 352, 2021 оны 65-р, 2021 оны 385-р тогтоолоор орсон өөрчлөлтийг тусгав.](#)

2.2.3. батлан даалтын нийт хэмжээ нь Сангийн өөрийн хөрөнгийг 10 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байх; СЗХ-ны 2020.06.10-ны 352, 2021 оны 65-р, 2021 оны 385-р тогтоолоор орсон өөрчлөлтийг тусгав.

2.2.4. өөрийн хөрөнгийн зохистой харьцааг тооцохдоо өөрийн хөрөнгө, нөөц сан, тайлан жилийн ашиг зэрэг нийт цэвэр хөрөнгийн дүнг нийт активд харьцуулах ба зохистой харьцаа нь 10 хувиас доошгүй;

2.2.5. цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө нь нийт хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй;

2.2.6. Сангийн өөрийн хөрөнгийн 40 хувиас хэтрэхгүй хэмжээгээр банк бус санхүүгийн байгууллагын итгэлцлийн үйлчилгээ, Хөрөнгийн биржийн “А” самбарын хувьцаа, Засгийн газрын өрийн бичигт хөрөнгө оруулж болох бөгөөд үүнээс 1 жилээс дээш урт хугацаатай нь нийт өрийн бичгийн 20 хувиас хэтрэхгүй;

2.2.7. үйл ажиллагааны зардлын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцохдоо үйл ажиллагааны зардлаас хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг хасаж нийт цэвэр хөрөнгөд харьцуулах замаар тооцох ба зохистой харьцаа нь 15 хувиас хэтрэхгүй;

2.2.8. төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцохдоо эрсдэлгүй активын дүнг 6 дугаар хавсралтын дагуу тооцож, нийт өр төлбөрт харьцуулах ба зохистой харьцаа нь 100 хувиас доошгүй байх;

2.2.9. Сан нь нөөцийн сантай байх бөгөөд нөөц санг тайлант жилийн цэвэр үр дүнгийн 50-аас доошгүй хувиар байгуулж, батлан даалтын үүргийн гүйцэтгэлийг хангахад зарцуулна.

ГУРАВ. САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ЗАЙНЫ ХЯНАЛТ

3.1. Сан нь дараах тайлан, мэдээг заасан хугацаанд Хороонд хэвлэмэлээр болон цахимаар ирүүлнэ:

3.1.1. батлан даалтын тайлан, батлан даалтын хөдөлгөөний тайлан, батлан даалтын ангиллын мэдээ, үүрэг гүйцэтгэсэн батлан даалтын мэдээг энэхүү журмын хавсралт 1, 2, 3, 4 дүгээр маягтын дагуу, мөн тайлант хугацаанд батлан даалтад хамрагдахаар гаргасан хүсэлтийн тоог сар бүр гаргаж дараа сарын 10-ны өдрийн дотор;

3.1.2. энэ журмын 3.1.1.-т заасан мэдээ, тайлан, 5 дугаар хавсралтаар сангийн мөнгөн хөрөнгийг байршуулсан мэдээ болон Сангийн яамнаас баталсан маягтын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор;

3.1.3. Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д заасны дагуу санхүүгийн жилийн тайланд дараагийн санхүүгийн жилийн 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор аудит хийлгэж, баталгаажуулсан санхүүгийн тайлан, дүгнэлт;

3.1.4. зайлшгүй шаардлагатай гэж үзсэн холбогдох мэдээ, тайланг тухай бүр;

3.2. Сангийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг цахим хуудсаар нийтэд ил тод мэдээлж байна.

3.3. Сан нь зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан дотооддоо мөрдөхөөр баталсан журам, заавар, тэдгээрт өөрчлөлт орсон тухай бүр Хороонд ирүүлнэ.

3.4. Хорооны хянан шалгагч нь энэ журмын 3.1.2-т заасан мэдээ, тайлан болон санхүүгийн тайланг хянан, хагас жил тутам хугацаат үүрэг даалгавар, зөвлөмжийг Санд хүргүүлнэ.

3.5. Хорооны холбогдох албан тушаалтан нь Сангийн тайлант оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, зохистой харьцаа болон батлан даалтын тайлан мэдээнд динамик шинжилгээ хийж, дүгнэлтийг тухайн тайлант жилийн дараа оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор Хорооны удирдлагад танилцуулж, хувийн хэрэгт хадгална.

3.6. Сангийн үйл ажиллагаанд эрсдэл үүсэж болзошгүй гэж үзвэл Хороо дараах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ:

3.6.1.өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх талаар хугацаатай үүрэг даалгавар өгөх;

3.6.2.чанаргүй батлан даалтын үлдэгдэл нь батлан даалтын нийт үлдэгдлийн 15 хувиас хэтэрсэн тохиолдолд зээлийн батлан даалтыг хязгаарлах талаар холбогдох шийдвэр гаргана. [СЗХ-ны 2020.06.10-ны 352, 2021 оны 65-р, 2021 оны 385-р тогтоолоор орсон өөрчлөлтийг тусгав.](#)

ДӨРӨВ. САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ

4.1.Сангийн үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилт хангагдаж байгаа эсэхэд газар дээрх хяналт, шалгалтыг Хорооноос хэрэгжүүлнэ.

4.2.Газар дээрх хяналт, шалгалт нь хамрах хүрээнээс хамаарч иж бүрэн болон хэсэгчилсэн байдлаар хийгдэнэ. Хорооны даргын томилсон ажлын хэсэг, баталсан удирдамжийн дагуу жил бүр газар дээрх хяналт шалгалтыг хийнэ.

4.3.Шаардлагатай гэж үзвэл газар дээрх хяналт, шалгалтыг холбогдох байгууллагатай хамтарсан хэлбэрээр гүйцэтгэж болно.

4.4.Сан газар дээрх хяналт, шалгалт хийх үед дараах үүргийг хүлээнэ:

4.4.1.ажлын болон бусад зориулалтын байранд ажлын хэсгийг саадгүй нэвтрүүлж, шалгалтад дэмжлэг үзүүлэх;

4.4.2.хяналт, шалгалт хийх нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай мэдээ, баримт, материалыг гарган өгөх.

4.5.Сан газар дээрх, хяналт, шалгалт хийх үед дараах эрхтэй:

4.5.1.газар дээрх хяналт, шалгалтын удирдамж, тайлантай танилцах;

4.5.2.Хорооны улсын байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлүүлэх;

4.6.Шалгалтын тайлан, дүгнэлтэд дараах асуудлыг тусгасан байна:

4.6.1.Сангийн үйл ажиллагаа нь тогтвортой байдал, зохистой харьцаа хангаж буй эсэх, шимтгэлийн орлого, үүргийн гүйцэтгэл болон санхүүгийн үзүүлэлт бүрээр өгсөн үнэлэлт, дүгнэлт;

4.6.2.үйл ажиллагааны чиглэл бүрээр мөрдөж буй хууль тогтоомж, заавар журмын хэрэгжилт, илэрсэн зөрчил дутагдал, түүнийг хариуцах эзэн, авсан арга хэмжээ;

4.6.3.гаргасан зөрчил дутагдалд үндэслэж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зөвлөмжийн талаарх хугацаатай үүрэг даалгавар, албан шаардлага;

4.6.4.шалгалтын тайланг Сангийн удирдлагад танилцуулж, гарын үсэг зуруулж, тэмдэг даруулж, баталгаажуулалт хийх;

4.6.5.Сангийн удирдлага татгалзсан нөхцөлд тайлбарыг ажлын хэсэгт албан бичгээр гаргах;

4.6.6.ажлын хэсэг нь шалгалтын тайланд зөрчил дутагдал болон бусад шаардлагатай холбогдох баримтын хуулбар, Сангаас гаргасан тайлбарыг хавсаргах;

4.6.7.бусад.

4.7.Шалгалтын тайланг танилцуулах, тайлагнах:

4.7.1.ажлын хэсэг газар дээрх хяналт, шалгалтын тайлан, шалгалтын дүнгээр авах арга хэмжээний талаарх хугацаатай үүрэг, даалгавар, албан шаардлагыг Сангийн удирдлагуудад танилцуулах;

4.7.2.Сангийн үйл ажиллагаанд хийсэн газар дээрх, хяналт шалгалтын тайланг шалгалтын удирдамжид заасан хугацаанд Хорооны удирдлагад танилцуулах;

4.7.3.газар дээрх шалгалтын тайланг шаардлагатай тохиолдолд төрийн бусад байгууллагуудад хүргүүлж болно.

4.8.Сан нь газар дээрх шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хэрэгжүүлэх арга хэмжээг шуурхай авч холбогдох тайлан мэдээг заасан хугацаанд Хороонд ирүүлнэ.

ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1.Энэхүү журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

БАТЛАН ДААЛТЫН ТАЙЛАН

...оны ... сар ... өдөр

/төгрөгөөр/

№	Олгосон байгууллага	Зээлдэгчийн				Олгосон зээл			Батлан даалт					Батлан даалтын эх үүсвэр
		Нэр	Регистр	Харьяалал /хот, аймаг, дүүрэг/	Үйл ажиллагааны чиглэл / салбарын ангиллаар/	Хугацаа /сараар/	Хэм-жээ	Хүү-гийн түвшин	Хувь	Хэмжээ	Шимтгэлийн хувь	Шимтгэлийн дүн	Өөрийн хөрөнгөнд эзлэх хувь	
Нийт дүн							-			-		-	-	
1.														
2.														
3.														
4.														
5.														
6.														
7.														
8.														

Жич: Зээлдэгч тус бүрээр мэдээллийг дэлгэрэнгүй гаргана.

Тамга ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../овог нэр/

НЯГТЛАН БОДОГЧ...../овог нэр/

“Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах,
хяналт тавих журам”-ын хоёрдугаар хавсралт

БАТЛАН ДААЛТЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТАЙЛАН

...оны ... сар ... өдөр

/төгрөгөөр/

№	Олгосон байгууллага	Зээлдэгчийн нэр	Зээлийн					Батлан даалтын		
			Огноо		Эхний үлдэгдэл	Төлөгдсөн дүн	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Төлөгдсөн дүн	Эцсийн үлдэгдэл
			Олгосон	Төлөгдөх						
Нийт дүн					-	-	-	-	-	-
1.										
2.										
3.										
4.										
5.										
6.										
7.										
8.										
9.										
10.										

Жич: Зээлдэгч тус бүрээр мэдээллийг дэлгэрэнгүй гаргана.

Тамга ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../овог нэр/
 НЯГТЛАН БОДОГЧ...../овог нэр/

“Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах,
хяналт тавих журам”-ын гуравдугаар хавсралт

БАТЛАН ДААЛТЫН АНГИЛЛЫН МЭДЭЭ

...оны ... сар ... өдөр

/төгрөгөөр/

№	Олгосон байгууллага	Зээлдэгчийн нэр	Зээлийн				Батлан даалтын			
			Үлдэгдэл	Хугацаа хэтэрсэн хэмжээ	Хугацаа хэтэрсэн хоног	Ангилал	Хувь	Үлдэгдэл	Хугацаа хэтэрсэн хэмжээ	Ангилал
Нийт дүн			-	-				-	-	
1.										
2.										
3.										
4.										
5.										
6.										

Жич: Зээлдэгч тус бүрээр мэдээллийг дэлгэрэнгүй гаргана. Батлан баалтын ангиллыг батлан даалтын үлдэгдлээс тооцно.

№	Ангилал	Зээл	Багцад эзлэх хувь	Батлан даалт	Багцад эзлэх хувь
Нийт дүн		-	100%	-	100%
1.	Хэвийн				
2.	Хугацаа хэтэрсэн				
3.	Чанаргүй:				
4.	- Хэвийн бус				
5.	- Эргэлзээтэй				
6.	- Муу				

Тамга ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../овог нэр/

НЯГТЛАН БОДОГЧ...../овог нэр/

“Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах,
хяналт тавих журам”-ын дөрөвдүгээр хавсралт

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН БАТЛАН ДААЛТЫН МЭДЭЭ

...оны ... сар ... өдөр

/төгрөгөөр/

№	Зээлдэгчийн		Зээл						Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар нэхэмжилсэн дүн	Үүрэг гүйцэтгэсэн		Авлагын	
	Нэр	Харьяалал	Олгосон байгууллага	Олгосон огноо	Олгосон дүн	Төлөгдсөн дүн	Үлдэгдэл дүн	Ангилал		Огноо	Батлан даалтын дүн	Төлөгдсөн дүн	Эцсийн үлдэгдэл
Нийт дүн					-	-	-		-		-	-	
1.													
2.													
3.													
4.													
5.													
6.													
7.													
8.													
9.													
10.													

Жич: Зээлдэгч тус бүрээр мэдээллийг дэлгэрэнгүй гаргана.

Тамга ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../овог нэр/

НЯГТЛАН БОДОГЧ...../овог нэр/

“Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах,
хяналт тавих журам”-ын тавдугаар хавсралт

САНГИЙН МӨНГӨН ХӨРӨНГИЙН БАЙРШЛЫН МЭДЭЭ

...оны ... сар ... өдөр

/төгрөгөөр/

№	Банк, санхүүгийн байгууллагын нэр	Данс нээсэн огноо	Дансны төрөл	Хугацаа /сараар/	Валютын төрөл	Үлдэгдэл		Хүү, өгөөжийн хувь /сараар/
						Валютаар	Төгрөгөөр	
НИЙТ ДҮН								
1								
...								
...								
ДҮН								
...								
ДҮН								
...								
...								
	Засгийн газрын өрийн бичиг							
	Хөрөнгийн биржийн “А” самбарын хувьцаа							

Тамга ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../овог нэр/

НЯГТЛАН БОДОГЧ...../овог нэр/

“Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах,
хяналт тавих журам”-ын зургаадугаар хавсралт

ЭРСДЭЛГҮЙ АКТИВ ТООЦОХ ХЭМЖЭЭ

ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН АКТИВЫН ДҮН		Эрсдэлийн түвшин	Тайлан тэнцлийн нийт актив	Эрсдэлгүй актив
Нийт дүн			-	-
1	Касс дахь бэлэн мөнгө	100%		
2	Засгийн газрын үнэт цаас /цэврээр/	100%		
3	ББСБ-д итгэлцлээр байршуулсан мөнгөн хөрөнгө	95%		
4	Хөрөнгийн биржийн “А” самбарын хувьцаа	80%		
5	Авлага	0%		
6	Бараа материал	0%		
7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	0%		
8	Бусад эргэлтийн хөрөнгө	0%		
9	Үндсэн хөрөнгө /цэврээр/	0%		
10	Бусад үндсэн хөрөнгө /цэврээр/	0%		
11	Биет бус хөрөнгө /цэврээр/	0%		
12	Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	0%		

$$\text{Төлбөрийн чадварын зохистой харьцаа} = \frac{\text{Эрсдэлгүй актив}}{\text{Нийт өр төлбөр}}$$